

20



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2018 оны 03 сарын 05 өдөр

Дугаар 10/2

Номгон

**Авто зам, замын байгууламж ашигласны
төлбөрийн хувь хэмжээг тогтоох тухай**

Монгол Улсын Авто замын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит бус X хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1. Орон нутгийн чанартай авто замаар зорчиж байгаа аймагт бүртгэлтэй тээврийн хэрэгслээс жилд нэг удаа хөдөлгүүрийн багтаамж, овор хэмжээ, байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөг харгалзан ногдуулах авто зам, замын байгууламж ашигласны төлбөрийн хувь хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Авто зам, замын байгууламж ашигласны төлбөрийг аймгийн замын санд төвлөрүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

ДАРГА

(Handwritten signature)



Ц.ОТГОНБАЯР

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
2018 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн ээлжит
бус Х хуралдааны 10/2 дугаар тогтоолын хавсралт



**АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖ АШИГЛАСНЫ
ТӨЛБӨРИЙН ХУВЬ ХЭМЖЭЭГ ТОГТООСОН ЖАГСААЛТ**
/төгрөгөөр/

№	Тээврийн хэрэгслийн ангилал		Хувь хэмжээ
1	Суудлын	2000см ³ хүртэл	15000
2		2001-3000	30000
3		3001-с дээш	35000
4	Ачааны	1тн хүртэл	20000
5		1-2 тн	25000
6		2-3 тн	30000
7		3-5 тн	35000
8		5-8 тн	40000
9		8-10 тн	45000
10		10 тн-с дээш	50000
11	Автобус	15 хүртэл	30000
12		15-с дээш	80000
13	Цистерн		50000
14	Тусгай		40000
15	Чиргүүл		30000
16	Механизм	Тээвэр үйлчилгээний	50000
17		Технологийн	50000
18		Бага оврын	30000
19	Мотоцикл	2 дугуйт	2000
20	Мопед	3 дугуйт	2000

_____ооо_____